



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А143

Халбан

Ой хээрийн түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалт, 18.2.17 дахь заалт, 18.2.12 дахь заалт, Аймгийн онцгой комиссын 2024 оны 3 дугаар сарын 11-ны өдрийн 02 дугаар албан даалгаврыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17-д заасан ой хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшил бүхий цаг хугацаа буюу 3 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр, 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл хугацаанд сумын нийт нутаг дэвсгэрт ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг өргөн цар хүрээтэй зохион байгуулсугай.

2.Аймгийн онцгой комиссын 2024 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 02 дугаар албан даалгаврын холбогдох заалтууд болон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаарх ухуулга сурталчилгааг иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд, багийн иргэдийн нийтийн хурал, айл өрхөд нэг бүрчлэн хийхийг Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасаг, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Аймгийн онцгой комиссын 2024 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 02 дугаар албан даалгаврын дагуу ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тэмцэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллахыг Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасагт үүрэг болгосугай.

4.Ой хээрийн түймэр гарсан тохиолдолд цаг алдалгүй илрүүлж, хохирол багатай унтраах ажилд гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу 1, 2 дугаар ээлжид ажиллах хүмүүсийн бэлэн байдлыг хангуулан дайчилж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА  ОТГОНБАЯР